



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/56

Даланзадгад сум

Эм эмнэлгийн хэрэгсэл худалдах тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 7.12 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.18 -ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм эмнэлгийн хэрэгсэл худалдах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 04 дүгээр хурлаар тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, эмийн сангийн байршил солих хүсэлтийг шийдвэрлэсэн эмийн сангийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, хугацааг сунгасан эмийн сангийн тусламж үйлчилгээнд мэргэжил арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Б.Батболд), Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм эмнэлгийн хэрэгслийн улсын ахлах байцаагч (У.Дөшбат) нарт тус тус даалгасугай.

3.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг холбогдох стандарт дүрэм журмын хүрээнд үзүүлж, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Б.Цагаанцэнд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

462501307

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн
А156 дугаар тушаалын хавсралт

Эм эмнэлгийн хэрэгсэл худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан,
хаяг байршил сольсон эмийн сангийн нэрс

Д/д	Байгууллагын нэр, тусгай зөвшөөрлийн дугаар	Аж ахуй нэгжийн ТТД	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	Хаяг байршил
Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан					
1.	Тэнгэрлэг говийн од ХХК - Итгэлмэд эмийн сан ЭСХ-22/14/140	3623807	Хүний эм эмнэлгийн хэрэгсэл худалдах	2030 оны 08 дугаар сарын 29-ний өдөр хүртэл	Даланзадгад сум, 3-р баг Далан худалдаа 2-р гудамж 203А тоот
Эмийн сангийн байршил сольсон					
2.	Ерөөгдсөн говь ХХК Ерөөл эмийн сан ЭСХ-23/46/149	3653544	Хүний эм эмнэлгийн хэрэгсэл худалдах	2026 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүртэл	Даланзадгад сум, 3 дугаар багийн Далан 0 тоот Баян-Өндөр худалдааны төвд байршил солив.
3.	Цомбоговь ХХК Маргад эмийн сан ЭСХ-11/14/61	3611221	Хүний эм эмнэлгийн хэрэгсэл худалдах	2028 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хүртэл	Даланзадгад сумын 3 дугаар багийн 12 дугаар орон сууцны 4-30 тоот, Худалдааны 2006 тоотод байршил солив.

---oOo---